

**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.05.27 № 03/3102
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичигт
өөрчлөлт оруулсан тухай**


Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/20240102009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой сонирхогч этгээдээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргасан.

Дээрх гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хянан үзэж, тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг мэдэгдсэн болно. Үүнтэй холбогдуулан тендерийн баримт бичиг /II БҮЛЭГ, ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)/-т дараах өөрчлөлтийг оруулсан болно.

1.ТШЗ 26.1-д “Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Цаг: 11 цаг 00 минут” гэснийг “Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Цаг: 11 цаг 00 минут” гэж,

2.ТШЗ 26.2-т “Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Цаг: 11 цаг 15 минут” гэснийг “Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Цаг: 11 цаг 15 минут” гэж тус тус өөрчлөв.

ДАРГА



Л.ХОСБАЯР